

Увс аймгийн ИТХ-ын 2014 оны ажлын тайлан, цаашдын зорилтын тухай

Нэг. Аймгийн ИТХ-н дотоод зохион байгуулалт

Төлөвлөлт: Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн санал, 2014 оны зорилтод суурилсан жилийн ажлын төлөвлөгөөг тэргүүлэгчдийн хурлаар батлан сарын хуваарт оруулж тэргүүлэгчид, хурлын хороод болон ажлын албанаас зохион байгуулах ажлаар нь ялгаж ажилтан бүрийн үр дүнгийн гэрээнд тусган эзэнжүүлсэн нь төлөвлөгдсөн ажил арга хэмжээнүүд хэрэгжих үр дүн нь дээшлэхэд нөлөөллөө. Аймгийн ИТХ нь 2014 онд 144 ажил арга хэмжээг жилээр төлөвлөснөөс 134 нь биелсэн, бусад нь үлдэж байгаа хугацаанд хийгдэхээр хүлээгдэж байна.

Хурлын хуралдаан:

Аймгийн ИТХ-ын хуралдааныг 3 удаа хийхээр төлөвлөсөн боловч төсвийн тодотгол хийж төлөвлөсөн зорилт арга хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага үүсээгүй учраас хуралдааныг 2 удаа хийж 12 асуудал хэлэлцлээ.

Аймгийн ИТХ-ын 7-р хуралдаанаар 6 асуудал хэлэлцэж 39 заалт бүхий 10 тогтоол гаргалаа. Аймгийн концессийн зүйлийн жагсаалт, хувийн хэвшил, иргэний байгууллагыг дэмжих, хамтран ажиллах чиглэлийг батлаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол гаргаж 2014 оны орон нутгийн төсөвд өөрчлөлт орууллаа.

Аймгийн ИТХ-ын 5,6,7 дугаар хуралдааны үеэр төлөөлөгчдөөс гаргасан 172 асуудал хөндсөн санал шүүмжлэлийг холбогдох 13 байгууллагад албан тоотоор хүргүүлэн 6 байгууллагаас ирсэн хариуг төлөөлөгч бүрт, мөн холбогдох хурлын хороодод тухай бүрийд нь цахимаар хүргүүлэх арга хэмжээ авч, цаасаар хэвлэсэн нэгтгэлийг нь хороодын ажлын танхимд тавьж танилцууллаа.

Тэргүүлэгчдийн хурал:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал сард 2-оос доошгүй хуралдаж 27 асуудлыг хэлэлцүүлэхээр төлөвлөснөөг 2014 оны ажилтай холбогдуулан бүгд 19 удаа хуралдаж 106 асуудал хэлэлцэж 409 заалт бүхий 103 тогтоол гаргажээ.

Аймгийн биеийн тамир спортыг хөгжүүлэх хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөр, сумдын худалдан авах ажиллагааг дүгнэх журам, ОНӨҮГ, худалдааны төвийн ажиллах дүрэм, орон сууцны болон үйлчилгээний барилгын орчны тохижилт, хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг камержуулах, ИТХ-ын дэргэдэх ахлах зөвлөхүүдийн ажиллах, Цагдаагийн албаны хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл ажиллах, Мини захыг менежментийн гэрээгээр ажиллуулах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын журмыг хэлэлцэн баталж үр дүнг тооцон ажиллаж байна.

Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, “Том төрөөс ухаалаг төр рүү” хэлэлцүүлэг, ҮАБЗ-ийн зөвлөмжийн мөрөөр зохион байгуулсан ажлын үр дүн, цахилгаан түгээх сүлжээ компаний удирдлага, Улаангом хотын цэцэрлэгжүүлэлт, тохижилт, эрүүл мэндийг хамгаалах, сумын ИТХ-ын ажлыг боловсронгуй болгох, СӨХ-ийн үүргийг “Чандмань Увс” ХХК-аар гүйцэтгүүлэх, “Хатан түрүү” компаний өр зээлийн асуудлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болгох асуудлыг яаманд тавьж шийдвэрлүүлэх, үр ашигтай ажиллуулах тухай тогтоолууд гарсан.

Хурлын даргын захирамж 14, ажлын албаны даргын тушаал 36 гаргаж, **340** албан тоотыг холбогдох газруудад хүргүүлэв.

Хурлын хороод:

Төсөв санхүү эдийн засгийн хороо:

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлс, үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлэх, бодит өсөлтийг тогтоох судалгаа явуулж санал дүгнэлт гарган боловсруулж Засаг даргад зөвлөмж чиглэлийг хүргүүлээ. Мөн төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх хэлэлцүүлэг, концессийн зүйлийн жагсаалт, орон нутгийн өмчийн журмуудын шийнэчлэл зэрэг асуудалд дүгнэлт гаргав.

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хороо: Багийн ИНХ-ын ажлын нөхцөл боломжийг сайжруулах талаар дүгнэлт гаргаж 2015 оны багийн ИНХ-ын төсөв боловсруулж аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлсэн, Улаангом сумыг 2016 он хүртэл хөгжүүлэх хийх ажлын төсөөлөл, цаашид хотын статустай болгох орчин нөхцлийг бүрдүүлэх талаарх хот төлөвлөлтийн талаар санал дүгнэлт гаргасан. Улаангом сумын ИТХ, Иргэний танхим, Хотын хөгжил, цэцэрлэгжүүлэлтийн газрын үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж өгсөн.

Хууль эрх зүй дотоод хяналтын хороо:

ИТХ-ын төлөөлөгчийн нөхөн сонгууль, орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээ, аудитын газрын улирлын ажлын тайлан мэдээ, Улаангом сумын гэмт хэргийн гаралтын ажиллагаатай танилцан цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргав.

Байгаль орчин экологийн тэнцвэрт байдлын хороо:

Тус хороо 14 удаа хуралдаж хяналт шалгалт явуулах, судалгаа хийж санал дүгнэлт гаргах, баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг зохион байгууллаа. Өмнөговь, Тариалан сумдын нутагт хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, Улаангом сумын Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын байдал, эвдэгдсэн газар түүний нөхөн сэргээлтийн ажил, БОГ, УТХГНХЗ, ХХЦГ, ҮХААГ-ын 2013, 2014 оны ажлын явц, зохион байгуулсан онцлог ажил, бэрхшээлтэй асуудлын талаар судалж танилцан зөвлөгөө өгч ажиллав.

Хүний хөгжил, нийгмийн асуудлын хороо Ном, авьяас хөтөлбөрийн тайлан, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрүүл мэндийн сонсголтой холбоотой судалгааны материалтай танилцаж дүгнэлт гаргалаа.

Хоёр. Хурлын төсөв:

2014 онд аймгийн ИТХурал, ажлын алба хамтдаа 306,6 сая төгрөгийн төсөв, төлөөлөгчдийн ийл ажиллагааны 123 сая нийт 429,6 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 32,9% нь ажлын албаны ажилчдын цалин урамшуулалд, 19,2% нь дотоод болон гадаад томилолтонд, 11,4% нь тээвэр шатахууны зардалд, 1,2% нь бичиг хэрэгт, 1,1% нь шуудан холбоонд, 5,9% нь хуралдааны зардалд, 2,4% нь намын суудалд 2,1% нь мэдээлэл суртчилгаанд, 14,3% нь нэг удаагийн зардалд, 1,6% нь ГХУСАЗЗөвлөлийн, 1,4% нь цагаатгалын комиссын ажилд, 1,2% нь ном хэвлэлд, 3,1% нь эд хогшил худалдан авахад, 2,2% нь төлбөр хураамж болон бусад зориулалтаар тус тус зарцуулагдсан байна.

Гурав.Харилцаа, хамтын ажиллагаа:

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэсэн нь төлөөлөх үүргээ гадаад улс орон болон дотоод арга хэмжээнд оролцох, орон нутагт бодлого зорилгоо сурталчилах, орон нутагт төлөөлөгчийн үүргээ биелүүлэхэд аятай нөхцөл бүрдлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын 12 төлөөлөгч Тайваний Тайбэй хотод ажиллаж төр захиргааны болон эрүүл мэнд, боловсрол, соёл, модон эдлэл зэрэг салбаруудын үйл ажиллагаатай танилцаж, чацарганы тосны дээжийг Тайваний шинжилгээний лабораторит шинжлүүлэхэд, дэлхийн стандартад тэнцэж, дэлхийн зах зээлд худалдаалагдах зам нээгдэж чацаргана боловсруулах салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, туршлага солилцсон үр дүнтэй уулзалт боллоо. Мөн Тайваны төлөөлөгчид манай аймагт 2 удаа айлчилж Тайбэй хотын эмнэлэгийн эмч мэргэжилтэн ирж арга зүйн дэмжлэг үзүүлж аймгийн нэгдсэн эмнэлэгт 50 гаруй нэр төрлийн 800 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж бэлэглэлээ.

Аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан баг Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны Алтай аймаг, Урумчи хотод айлчилж Алтай орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хамтын

ажиллагааны “Торгоны зам” олон улсын хуралдаанд оролцож, аялал жуулчлал, хот байгуулалт, цэцэрлэгжүүлэлт, боловсруулах үйлдвэртэй танилцаж, Засгийн газар, газар тариалан, МАА-н корпорацийн удирдлагуудтай уулзаж эдийн засаг, нийгмийн харилцааг өргөжүүлэх, хамтран ажиллах талаар санал солилцож санамж бичигт гарын үсэг зурлаа.

Аймгийн ИТХ нь ОХУ-ын Тува улсын дээд хуралтай идэвхтэй олон талаар хамтран ажиллаж байна. Үүнд: Хил гааль, визийн асуудлаар тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх, мөн аймгийн ИТХ-ын ажлын алба Тува улсын дээд хурлын ажлын албатай, боловсрол, жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг хүрээнд харилцан туршлага солилцон хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллахаар болов.

Монгол Тувагийн ард түмний найрамдалт харилцааг бэхжүүлэх, Увс аймаг ба Тува улсын бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн ОХУ-ын тусгаар тогтнолын баярын өдрийг тохиолдуулан ОХУ-ын Тува улсын Засгийн газрын Тэргүүн Шолбан Валерьевич Кара-оолыг Монгол улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнасныг гардуулан өглөө.

2014 оны 11 сарын 11-ний өдрөөс 18-ны өдрүүдэд аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан 6 төлөөлөгч Япон улсын Фукуока мужийн хурлын дарга Купио Кажигийн урилгаар албан айлчлал хийлээ. Айчлалын хүрээнд Фукуока мужийн хурал, Фукуока хот дахь Монголын өргөмжит консул Коичи Хашида нартай уулзаж Увс аймагт хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар танилцуулав. Мөн Фукуока муж дахь хорт хавдар судлалын төв, эмнэлэг, хөдөө аж ахуйн хүрээлэн, төмөрлөгийн болон роботын үйлдвэр, эрчим хүч, зочид буудал, их дээд сургуулийн болон Япон дахь Монголыг дэмжигчдийн клубын гишүүдэд Увс аймгаа танилцуулж цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцлоо. Фукуока мужийн хурлын дарга, өргөмжит консул Увс аймагт хийгдэх томоохон хөрөнгө оруулалтанд хамтран ажиллахаа илэрхийллээ.

Орон нутагтаа аймгийн ИТХ-ын 22 төлөөлөгч 19 суманд цаг үеийн ажлаар болон төлөөлөх үүргээ хэрэгжүүлэн иргэдтэй уулзалт, ярилцлага хийж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхээр давхардсан тоогоор 22 хэлэлцүүлэг зохион байгуулж 2950 хүнийг хамруулан идэвхи санаачилга гарган ажиллав.

Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультай, ажилчдын спортын 3-р наадамд Увс аймгийн ИТХ-ын төлөөлөгч, ажлын албаны ажилтнуудаас бүрдсэн баг тамирчид спортын 6 төрлөөр амжилттай оролцож 1-р байранд орж шилжин явах цомоор шагнагдлаа.

Улаангом сумын 4-р баг, Өндөрхангай, Түргэн суманд аймгийн ИТХ-ын, Малчин, Бөхмөрөн суманд сумын ИТХ-ын төлөөлөгчийн нөхөн сонгуулийг хуулийн хүрээнд зохион байгууллаа.

Дөрөв. Сургалт, сурталчилгаа

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгч нарыг чадавхжуулах, бие даан шийдвэр гаргах түвшинг нэмэгдүүлэх төлөөлөгчийн бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллахад мэдлэг мэдээллэлтэй болгох зорилготой 390 гаруй төлөөлөгчдийг хамарсан сургалтыг зохион байгуулав.

Жилийн ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу Давст, Ховд, Зүүнговь суманд үзүүлэх сургалт зохион байгуулж сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, багийн ИНХ, иргэний танхимын ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах, мэдлэг мэдээллээ дээшүүлсэн, харилцан туршлага солилцов.

АТГ, Хууль зүйн яам, МНУХ, “НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн нэгж, баруун 5 аймгийн бүсчилсэн 4 удаагийн сургалт, зөвлөгөөнд ажлын албаны 4 мэргэжилтэн тус бүр оролцож холбогдох санал дүгнэлтээ хүргэж сургалтаар авсан мэдээллээ сумын ИТХ, иргэний танхимд сургалт өгч, мэдээллээ дамжуулан ажилласан.

Ажлын албанаас 8 төрлийн ном сурах бичиг, гарын авлага захиалан төлөөлөгчдэд, бичмэл сэтгүүлийн 3 дугаар, онцлох мэдээ 9 дугаарыг тус тус бэлтгэн гаргаж хурлын төлөөлөгчдөд шаардлагатай мэдээлэл болон хурлын үйл ажиллагааны үр дүнг мэдээллээ.

Тав. Иргэдийг шагналд тодорхойлох:

Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар аймгийн ЗД-аас ирүүлсэн саналыг хэлэлцээд Гавьяат цолоор 7, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 18, Алтан гадас одонгоор 110, Цэргийн хүндэт медалиар 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 156, шударга журам медалиар 2 хүнийг шагнуулахаар Ерөнхийлөгчид уламжилж, материалыг Тамгын газарт хүргүүлсэнээс Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 5, Алтан гадас одонгоор 58, Хөдөлмөрийн хүндэт медалиар 49, Цэргийн гавьяаны одонгоор 3, Цэргийн хүндэт медалиар 3, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1 иргэн тус тус шагнагдсан байна.

Зургаа. Иргэний танхим, хэлэлцүүлэг:

Аймгийн иргэний танхимаар зохион байгуулсан 4удаагийн хэлэлцүүлэгт 300 гаруйхүн оролцож, 4удаагийн нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр иргэдэд хууль зрх зүйн сурталчилгаа явууллаа. Аймгийн Иргэний танхимаар хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэлгүй аймаг болох, төлбөр тооцоог иргэдээс амар хялбар байдлаар авах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зэрэг асуудлаар тогтоол шийдвэр гаргалаа. Мөн 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр ямар ажил, үйлчилгээ хийх, Увс аймгийн хөгжлийн хөтөлбөр батлахтай холбогдуулж онлайн санал асуулга явуулж 7200 гаруй иргэний саналыг нэгтгэн ажилласан. Аймгийн иргэний танхимд шуурхай мэдээлэл хүлээн авах, дамжуулах цогц систем ажиллаж байна.

Сумдын иргэний танхим нийт 224 хэлэлцүүлэг зохион байгуулж 10172 иргэнийг хамруулж, 6350 санал, санаачилга гаргаснаас 73 асуудлыг шийдвэрлүүлж, 8744 асуудлаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. 2013 онд ажлын үзүүлэлтээрээ тэргүүлсэн Зүүнговь сумын Иргэний танхимын ажилтаны ажлын явц үр дүнтэй танилцахаар сумдын Иргэний танхимын ажилтнуудад сурталчилан харилцан мэдээлэл солилцож тулгамдсан асуудлаар туршлага солилцов.

Долоо. Сумын ИТХ

19 сумын ИТХ-ын хуралдаан 36 удаа хуралдаж сумын нийгэм, эдийн засгийн 2014 оны зорилт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, ОНХС-ийн зарцуулалт, давсан орлого хуваарилах, агнуурын бүс тогтоох, тусгай хамгаалалтын бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг 162 асуудал хэлэлцэж 707 заалт бүхий 140 тогтоол гаргаж, сумын дүрэм, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах журам, нийтийн зар мэдээний журам, төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, сумын ИТХ-ын үйл ажиллагааны журам, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөр, газарт тариалан дэмжих хөтөлбөр зэрэг 32 журам, хөтөлбөр, төлөвлөгөө батласан байна.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 201 удаа хуралдаж сум хөгжүүлэх тэргүүлэх чиглэл батлах, хуралдааны тов тогтоох, байгаль орчны хууль тогтоомж, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явц зэрэг сумын ИТХ-ын 2014 оны ажлын төлөвлөгөөнд туссан болон орон нутгийн цаг үеийн тулгамдсан 604 асуудлыг хэлэлцэж 2014 заалт бүхий 614 тогтоол, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ажил болон Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, ойн эргүүл, хянагчийн ажиллах журам, бэлчээрийг нөхөн сэргээх, зохистой ашиглах, цөөн малтай өрхийг малжуулах, оны аварга, тэргүүн шалгаруулах, хүндэт иргэнийг алдаршуулах зэрэг 34 дүрэм, журам гарган хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаласан байна.

Сумын хурлын хороод 107 удаа хуралдаж, хяналт шалгалт, 96 санал дүгнэлт гаргаж, тогтоол шийдвэрт тусгуулж, төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж,

“Үдийн цай” хөтөлбөр, гал тогоо бүхий газруудын эрүүл ахуй, орон нутгийн өмч, хүнс, архи, тамхины зэрэг хуулиудын хэрэгжилтэнд 54 удаа хяналт шалгалт хийж 58 зөвлөмж өгсөн байна.

Өндөрхангай сумын ИТХ нь Хурлын төлөөлөгчид, иргэдийн оролцоотой ОНХС, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих, Зүүнхангай сумын иргэний танхим багийн иргэдийн саналын дагуу ИНХ-аас гарсан хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөө босгох тухай Тэргүүлэгчдийн тогтоол гаргаж, холбогдох байгууллагад албан тоотоор хүргэж, ОНХС-ийн хөрөнгөөр үлийн цагаан оготно устгах, худаг гаргах, малжуулах зэрэг ажлуудыг хийсэн. Цагаанхайрхан сумын иргэний танхим “хөдөлгөөнт зар”, аяны богц аялуулан хууль тогтоомж, шийдвэрийг иргэдэд сурталчилах зэрэг онцлон дурьдах ажлуудыг сумын хурлаас санаачилан зохион байгуулан ажиллаж байна.

Багийн ИНХ 290 удаа хуралдаж 12950 иргэн оролцож 644 асуудал хэлэлцэж 900 заалт бүхий 433 тогтоол, 59 журам гаргасан. Иргэдийн дунд 153 хэлэлцүүлэг санал асуулга явуулж 1288 иргэн санал гаргаснаас 480 саналыг захирамж, тогтоол, тушаалд тусгаж 34 саналыг шийдвэрлүүлэхээр холбогдох албан тушаалтанд уламжилсан байна.

МНУХ, Мерси Кор ОУБ-ын хамтарсан сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөлд 6 сум хамрагдсанаас, 4 сум хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж, Сагил сум өөрсдөө бие даан хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж баталсан байна. Харин Өлгий, Давст сумууд энэ ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

Бүх сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар УБ хотод МНУХ, КАС-ийн сургалтанд, Хяргас, Завхан сумын 21 төлөөлөгч Удирдлагын академийн сургалтанд, Мерси Кор, УНАСДЦГ-тай хамтран, Улаангом, Давст, Баруунтуруун, Өмнөговь, Өлгий сум ХАСХОМ-ийн талаар төлөөлөгчиддөө сургалтанд тус тус хамрагдуулсан байна.

Найм.ГХУСАЗС:

Аймгийн ГХУСАЗС-ийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан 28 ажил үйлчилгээ төлөвлөснөөс 22 ажил хэрэгжүүлэн ажилласан. Үүнд онцлон тэмдэглэхэд Цагдаагийн газраас гэмт хэргийн гаралтын талаарх мэдээг сар бүр хүлээн авч гэмт хэргийн гаралт өндөртэй сумдад анхааран тусгайлсан удирдамж гарган зөвлөмж өгч ажиллав. Хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах байнгын ажиллагаатай байртай болох хэлэлцүүлэг зохион байгуулснаар ТББ болон цагдаагийн газар төсөв, төлөвлөлтийн ажлыг судалж ажиллахаар болов. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүднээс сум, байгууллага, аж ахуйн нэгжийн орчин тойрныг камержуулах журмын хэрэгжиж 24 цагийн турш дүрс бичлэгээ хадгалдаг камержуулалт тавигдаж эхэлснээр гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан байна. Архидан согтуурахтай тэмцэх, архи тамхины хуулийг хөдөө сумдад сурталчлах зорилгоор цагдаагийн газар, “АА” ассоциаци хамтран бүсчилсэн сургалт мэдээллийг хийснээр архидан согтуурах танхайрах явдал буурч, тамхигүй цэвэр орчныг бүрдэж сумдын ГХУСАЗС-ийн ажил сайжирсан.

Хийлийн болон дотоодыг малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр морьт эргүүл ажиллуулах, үйлчилгээний цэгүүд дээр мал, мах худалдах, худалдан авах хяналтын дэвтэр хөтлөх журмыг хэрэгжүүлэн ажиллуулах төсөл боловсруулан ажиллаж байна.

Аймгийн ГХУСАЗС-ийн ажлын төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрт сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилт, үр дүн, гэмт хэрэг гаралтын нөхцөл байдалтай танилцах, цаг үеийн ажлаар мэдээлэл өгөх, иргэдтэй уулзах, цаашид хийх ажлыг тодорхойлон хамтарч ажиллалаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл Хурлын дэргэд байна” гэж хуульчилсаны дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй иргэний зөвлөл байгуулагдан үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна.

Авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2014 онд аймаг, сумын ИТХ-ын 504 сонгуультаан, албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгээ цаг хугацаандаа гарган өгснөөр АТГ-т хүргүүлэн авлигын эсрэг хууль болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг амжилттай хэрэгжүүлэн аливаа зөрчилгүй ажиллаж байна. Цаашид мөн хөрөнгө орлогын мэдүүлэг болон, хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгээ цаг хугацаандаа үнэн зөв хариуцлагатай байдлаар гаргаж байхыг төлөөлөгч та бүхэндээ уриалж байна.

Арван нэг.Орон нутгийн өмч

Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалтыг дээшлүүлэх, менежментийг сайжруулахаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлж 26 тогтоол, 2 тэмдэглэл гарч, тогтоолын биелэлт 95,1 хувь буюу тогтоол шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас 259,7 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, 129,7 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 252,5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 65,9 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн асуудлуудыг хууль журамын дагуу бүрэн шийдвэрлүүлж ажилласан байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулж аймгийн орон нутгийн төсөвт 45.0 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй ажилласнаас 194,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 432,4% -иар давуулан биелүүлж худалдан борлуулах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажилласан байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ажлын байр бий болгох зорилгоор иргэд аж ахуйн нэгжтэй 3 талт түрээсийн гэрээг байгуулан ажиллаж 10954,7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт оруулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулж ажилласан байна. Мөн өмнөх оны 950,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж 2013 онд ашиглалтанд орсон “Хүүхэд залуучуудын парк”, “Бурхан багшийн сэрэг дүр хөшөө” бүхий Цэцэрлэгт хүрээлэн, “Худалдааны битүү зах”, “Аялал жуулчлалын гэр бааз”, “Мини зах”-ын барилга зэрэг хөрөнгүүдийг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг сайжруулах зорилгоор хуульд заасан арга хэлбэр, нөхцөлийн дагуу ОНӨААТҮГазар байгуулах, менежментийн үр дүнг харгалзан хувьчлах, дуудлага худалдаагаар худалдах зэрэг шийдвэрийг гаргуулан хэрэгжүүлж ажилласан байна.

Хүнсний худалдааны “Мини зах”-ыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах аргаар хувьчлалын журам, гэрээний төсөл боловсруулан батлуулж, хувьчлалын ажлыг зохион байгуулан 20,6 сая төгрөгийн дэнчин урьдчилан орон нутгийн өмчийн сангийн дансанд байршуулж “Ус рашаан эрдэнэ” ХХК-тай 2 жилийн хугацаатай менежментийн гэрээ байгуулан 206520,9 мянган төгрөгөөр үнэлэн хувьчлалын ажлыг зохион байгуулан ажиллаа.

Орон нутгийн өмчийн холбогдолтой дүрэм журмуудыг шинэчлэн боловсруулан гарын авлага “Орон нутгийн өмчийн журам, зааврын” эмэхтгэл болгон хэвлүүлж сум болон төсөвт байгууллагуудад хүргүүлэн сумдын хурлыг бэхжүүлэх, чадавхийг дээшлүүлэх, ӨХБЗ-ийн эрх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зэргээр журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Орон нутгийн өмчит 181 хуулийн этгээдэд 2013.12.31-ны өдрийн байдлаар нийт 153,678,868,189 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Цаашид Сумын ИТХ, Багийн ИНХ болон ГХУС ажил, хууль эрх зүйн сурталчилгаа, иргэний зөвлөл, иргэний танхимын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүү төсөв бусад нөөцийг бүрдүүлэх, төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх нь аймаг, сумдын ИТХ-ын ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Аймгийн ИТХ, тэргүүлэгчид, хурлын хороод, ажлын алба, сум, багийн түвшинд

хийгдсэн бүхий л ажлыг нуршин дурьдахгүйгээр 2014 онд дэвшүүлсэн бодлогын гол зорилтуудаа хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг товчлон танилцууллаа.